

**ОДОН ОРОН СУДЛАХ ОРГИЛЫН АЖИГЧЛАГДЫН БАЙРЭЫ УРСГАЛ
ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Захиалагч байгууллага	ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн
2. Засвар хийх үндэслэл	Тус хүрээлэнгийн Астрометр, Астрофизик салбарын ажиглагчдын байр нь 1957 онд баригдсан учир байнгын засвар үйлчилгээ ойр ойрхон шаардагдах болсон. Тухайн барилга нь сантехникийн системийн хуучирч элэгдсэн доголдол, цаг хугацааны элэгдэл эвдэрлээс үүдэн байрны орц, хаалга үүд, хана таазны хэсэг хэсэг газруудад эвдрэл гэмтлүүд үүсээд байна. Үүнийг засварлахгүй бол ямар нэгэн эрсдэлүүд үүсэх магадлал өндөр болоод байна.
3. Барилга байгууламжийн байршил	Улаанбаатар хотын БЗД-ийн 11-р хороо, дархан цаазат Богд хан уулын Хүрэлтогоотын ам дахь Одон орон судлах оргил.
4. Зориулалт, хүчин чадал	Иргэн олон нийтийн зориулалттай барилгын хана таазны хэсэгчилсэн засвар, орцны шатны хонгилын засвар.
5. Технологийн шийдэл	Барилгын засварын ажлын төсөв, норматив болон баримтлан ажиллах. Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах, захиалагчтай зөвшилцөх.
6. Ажлын нөхцөл	Хэвийн нөхцөл
7. Хийгдэх ажил	Барилгын хэсэгчилсэн засвар.
8. Засварын хүрээнд хийгдэх ажил	Одон орон судлах оргилын ажиглагчдын байрны урсгал засвар. Ажиглагчдын байрны 1,2-р орц. <ul style="list-style-type: none"> ○ Хаалга: Тус байрны орцны хоёр ширхэг хаалгыг сайн чанарын төмөр "Сүпер ган хаалга" ХХК-ийн хаалгаар солих, шилэн вакуум хаалгыг дотор талд шилжүүлэн суулгах ○ Тааз: Дүүжин тааз хийх давхар тус бүрд эрчим хүчний хэмнэлттэй ЛЕД гэрэл суурилуулах. ○ Хана: Ханын нурсан хэсгийг шавардах, хуучин будгийг хусах, замаск татаж тэгшлэх, зүлгэх будах.

	<ul style="list-style-type: none"> ○ Шал: Шалны ховхорсон хэсгийг тэгшилж цутгах шаардлагатай хэсэгт тосон замаск хийх, зурвас гарган будах. • Өрөө тус бүрийн засвар <ul style="list-style-type: none"> ○ Тааз: хуучин дүүжин таазыг буулгах, таазны нурсан шаврыг буулгах, шинээр дүүжин тааз хийх, өрөөний талбайд харгалзан дүүжин таазны ЛЕД гэрэл суурилуулах. Хана: Хуучин ханын цаасыг буулгах, ханын шаврын нөхөөс хийх, захиалагчийн хүсэлтийн дагуу ханын цаас наах, засвараас үүдэн гарсан гэмтлийг нөхөж засварлах цонх хаалганы амалгаа будаг эмульс хийх гэх мэт.
9. Галын аюулгүй ажиллагаа	Галын аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг баримталж стандартыг хангаж ажиллана.
10. Хугацаа	20 хоног
11. Ерөнхий нөхцөл	Засварын ажилд хэрэглэх материал тоног төхөөрөмж нь Монгол Улсын стандарт, чанарын шаардлага хангасан байх ба шинэ бүтээгдэхүүн ашиглах бөгөөд захиалагчаар хянуулна. Засварын ажил нь захиалагчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байх.
12. Баталгаат жил	2 жил